



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 14 нэрийн нийт 911,601,746.47 (есөн зуун арван нэгэн сая зургаан зуун нэгэн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг дөчин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 788,388,867.89 (долоон зуун наян найман сая гурван зуун наян найман мянга найман зуун жаран долоон төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Тогтоолын хавсралтад заасан төрийн өмчит байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үлдэх өртөггүй болсон хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ирүүлж шийдвэрлүүлэх;

2.2.Хөрөнгө хүлээлцэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137004703
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгө эзэмшигч төрийн өмчит байгууллага	Шилжүүлэх Автомашинны нэр, марк	Улсын		Үйлдвэр- лэсэн он /Ашиглалтад орсон он	Хөрөнгийн балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
			Сери	Дугаар				
1	"Засгийн газрын автобааз" ТӨААТҮГ	Ниссан патрол У62	УБӨ	1342	2016/2016	126,000,000.00	61,090,514.79	Баянхонгор аймгийн Прокурорын газар
2	Баянхонгор аймгийн мэргэжлийн хяналтын газар	УАЗ-220692-033 Фургон	БНХ	1506	2013/2013	29,338,000.00	29,338,000.00	Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний Хэлтэс
3	Иргэний нисэхийн ерөнхий газар	Тоёото Лексус-570	УБЗ	2736	2011/2012	127,388,700.00	127,388,700.00	"Засгийн газрын автобааз" ТӨААТҮГ
4	Ховд аймгийн мэргэжлийн хяналтын газар	Хюндай Старекс	ХОУ	0170	2009/2020	20,000,000.00	5,002,281.00	Ховд аймгийн стандарт хэмжил зүйн хэлтэст
5	Архангай аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ланд-105	АРХ	7000	2002/2002	52,000,000.00	41,333,333.33	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
6	Булган аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ланд 200	БУН	0061	2011/2011	111,699,860.00	102,142,556.00	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
7	Дундговь аймгийн мэргэжлийн хяналтын газар	LEXUS470	ДУА	0006	1998/2011	44,300,000.00	44,300,000.00	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
8	Дорнод аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ниссан патрол	ДОА	3737	2012/2013	71,723,412.00	71,723,412.00	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

9	Завхан аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ниссан патрол	ЗАН	8094	2012/2013	31,479,997.27	31,479,997.27	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
10	Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ниссан патрол	ӨМҮ	5238	2007/2007	54,809,645.20	54,809,645.20	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
11	Увс аймгийн мэргэжлийн хяналтын газар	LX 570	УВС	4004	2012/2012	6,000,000.00	2,871,746.00	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
12	Ховд аймгийн мэргэжлийн хяналтын газар	Ниссан патрол	ХОҮ	0047	2012/2013	71,723,412.00	71,723,412.00	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
13	Орхон аймгийн мэргэжлийн хяналтын газар	Land cruiser Prado 150	ОРХ	8468	2011/2012	115,368,720.00	95,415,270.30	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
14	Өвөрхангай аймгийн мэргэжлийн хяналтын газар	LEXUS470	ӨВА	0053	2002/2011	49,770,000.00	49,770,000.00	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
Нийт дүн						911,601,746.47	788,388,867.89	
						(есэн зуун арван нэгэн сая зургаан зуун нэгэн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг дөчин долоон мөнгө)	(долоон зуун наян найман сая гурван зуун наян найман мянга найман зуун жаран долоон төгрөг наян есөн мөнгө)	